



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, П.Гэндэнгийн гудамж,
5 дугаар баг, Арвайхээр сум, Өвөрхангай аймаг, 62173,
Утас/Факс: (976) 7032 3253,
Цахим шуудан: uvurkhangai@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2023.03.24 № 147
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Гучин-Ус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Гучин-Ус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Гучин-Ус сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн дараах зөрчлүүдийн дүн бидний тооцсон материаллаг байдлын түвшнээс давсан нь “Хязгаарлалттай” дүгнэлт өгөх үндэслэл болсон. Тухайлбал:

- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр өвс тэжээл худалдан авч малчдад буцалтгүй тусламж хэлбэрээр тараасан.
- Сумын Засаг даргын Тамгын газар
 - Үндсэн хөрөнгийн машин тоног төхөөрөмж данс болон аж ахуйн материалын тооллогыг 3,713.0 мянган төгрөгөөр дутуу хийсэн
 - Анхан шатны баримтгүй ажил гүйлгээг бүртгэсэн, томилолтын хуудас бөглөөгүй цохолтгүй, жолоочийн тооцооны хуудсаар тооцоо бодогдоогүй 30,247.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрсэн
 - Дотоод албан томилолтыг 384.0 мянган төгрөгөөр илүү олгосон.
 - Санхүүгийн тайлангийн аудит хийхэд шаардлагатай баримт материалыг заасан хугацаанд ирүүлээгүй
 - Түлш шатах тослох материалын тайланг 1,606.6 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан
- Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
 - Цалингийн зардлаас 1,358.0 мянган төгрөгийн түлээ нүүрсний хөнгөлөлт олгосон
 - Төсвийн хөрөнгөөр 1,571.0 мянган төгрөгийн бэлэг дурсгалын зүйлс худалдан авсан
 - Бараа материалын тооллогыг 2,605.0 мянган төгрөгөөр дутуу хийсэн

- Нотлох баримтгүй 381.1 мянган төгрөгийн илүү цагийн хөлс олгосон зэрэг зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.6.7.-д "төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг энэ хуулийн 22.2.3-22.2.6-д заасан ангиллаар бүртгэж, тайлагнах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.-д "Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно", 15 дугаар зүйлийн 15.1.-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:" 15.1.5.-д "төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1.-д "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна", 13 дугаар зүйлийн 13.1.-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.6.-д "Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна.", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль 70 дугаар зүйлийн 70.2-д "түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын тооллогыг жилд 2 удаа /6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс/ 72.4.1-д "эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд үнэн зөв, чанартай явуулж дуусгах," зохистой байх, үнэн зөв байдал, эрх ба үүрэг зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант хугацаанд сумын ЕБС, Цэцэрлэг, Соёлын төв нь улсын төсөвт байгууллага болж өөрчлөгдсөнтэй холбоотой тус байгууллагуудын эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгүүдийг орон нутгаас улсын төсөвт шилжүүлсэн байна.

Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлуудыг үздэг. Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Гучин-Ус сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Эрүүл мэндийн төв, Соёлын төвийн 3,342.6 сая төгрөгийн үндсэн хөрөнгө, 140.3 сая төгрөгийн бараа материал, 3.5 сая төгрөгийн авлага, өглөгийг улсын төсөвт төвлөрүүлж хаалтын бичилт хийгдсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй. Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



О.БАТЖАРГАЛ

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн бүртгэлийн маягт

Аудитын нэр: Санхүүгийн тайлангийн аудит
Байгууллагын нэр: Гучин-Ус сумын ОНХС

| № | Гүйлээний анги, дансны үлдэгдэл | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн /мянга/ | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Шалгагач байгууллагын санал, тайлбар | Аудитын код: ЭВА-2023/81/НА-СТА-ТШЗ | Шалгагач байгууллагын | | |
|---|---------------------------------|---|--------------------|---------------------------------------|--------------------------------------|--|-----------------------|--------------------------------------|-----------------------|
| | | | | | | | Албан тушаал | Овог нэр | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| 1 | Бусад хөрөнгө | Өвс тэжээлийн нөөцөөс малчдад өвс тараан буцалтгүй тусламж, дэмжлэг олгосон байна | | Зөвлөмж өгөх | Танилцаж Хүлээн зөвшөөрөв | Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.7.6 "Аливаа аж ахуй нэгж, байгууллага, иргэнд олгох буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж, урамшуулал"-д ОНХС-ийн хөрөнгийг зарцуулахыг хориглоно гэж заасныг зөрчсөн байна Зөвлөмж: Журмыг мөрдөн ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг албан тоот, нотлох баримтын хамт 2023 оны 05 дугаар сарын 01-ний дотор ирүүлэх. | Зөвлөмж өгөх | Засаг дарга, санхүүгийн албаны дарга | Х.Энхтайван, Д.Нэргүй |

Бэлтгэсэн:
АУДИТОР

Анхан шатанд хянасан:
АУДИТЫН МЕНЕЖЕР

Хоёр дахь шатанд хянасан:
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



О.РИНЧИМЯДАГ

ДЭГЭЭНХ

О.БАТЖАРГАЛ

Танилцаж зөвшөөрсөн:

ГУЧИН-УС СУМЫН ЗАСАГ ДАРГА

САНХҮҮ АЛБАНЫ ДАРГА



Х.ЭНХТАЙВАН

Д.НЭРГҮЙ